



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/78

Улаанбаатар хот

Үйлчилгээ нэвтрүүлэх тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм”-ийн “Гурав”-ын 16-гийн “к” заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “НДҮ” цахим машинаас лавлагаа (мэдээлэл), тодорхойлолт олгох үйлчилгээг Нийгмийн даатгалын ерөнхий газар, нийслэлийн Баянгол, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн нэвтрүүлсүгэй.

2. “НДҮ” цахим машины хэвийн ажиллагааг хангах, холбогдох програм хангамжийн үйлчилгээ, засвар, мэдээллийн нууцлалын асуудлыг Мэдээллийн технологийн төв /Г.Хүрэлбаатар/-д хариуцуулсугай.

3. “НДҮ” цахим үйлчилгээнд ашиглагдах үнэт цаасыг хэвлүүлж, холбогдох нийгмийн даатгалын байгууллагуудад тухай бүр хүргүүлж ажиллахыг Тамгын газар /Р.Наранцэцэг/-т даалгасугай.

4. Нийгмийн даатгалын үйлчилгээний “НДҮ” цахим машины ажлын хэвийн ажиллагааг хангах, хуримтлагдсан маягтын үнийг холбогдох дансанд төвлөрүүлэх, үнэт цаасны зарцуулалтад хяналт тавих үүрэг бүхий ажилтныг томилж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Р.Наранцэцэг/, нийслэлийн Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /Н.Оюунчулуун/, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /Д.Артаг/, Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /Н.Энхтөр/, Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс /Б.Батсуурь/-т тус тус даалгасугай.

Тав. “НДҮ” цахим машины үнэт цаасны маягтын үнийг тус газрын үнэт цаасны Төрийн банк дахь 340000047120 тоот дансанд сар бүр төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, санхүү бүртгэлийн газар /Ч.Чулуунчимэг/-т үүрэг болгосугай.

Зургаа. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга /Д.Золжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Ц.УРТНАСАН